



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/105

Улаанбаатар хот

Бакалаврын өдрийн хөтөлбөрт 2018 онд
оюутан элсүүлэх журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 11.3, 12.1.4, БСШУ-ны сайдын 2013 оны А/79 дүгээр тушаалаар батлагдсан Оюутан элсүүлэх журмын 1.2, МУИС-ийн Дүрмийн 3.4.1 дэх заалт, МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын их сургуулийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2018 онд оюутан элсүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан элсэлтийн бодлого, журам сурталчлах, таниулах ажлыг зохион байгуулахыг Сургалтын нэгдсэн газар (Л.Одонтуяа), Элсэлтийн алба (М.Эрдэнэчимэг), Мэдээллийн технологийн газар (А.Баатарбилэг), Дотоод хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах хэлтэс (П.Лхамсүрэн)-т тус тус үүрэг болгосугай.

3. Оюутан элсүүлэх ажлыг энэхүү журмын дагуу зохион байгуулах, үр дүнд нь хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутан хариуцсан дэд захирал (Б.Очирхуяг), Мэдээллийн технологийн газар (А.Баатарбилэг), Бизнесийн сургуулийн захирал (Ч.Энхбаяр), Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн захирал (С.Баттулга), Хууль зүйн сургуулийн захирал (Ж.Эрдэнэбулган), Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийн захирал (Н.Баатарбилэг), Шинжлэх ухааны сургуулийн захирал (Б.Баяртогтох), Завхан сургуулийн захирал (П.Оюунбилэг), Эрдэнэт сургуулийн захирал (Т.Энх-Амгалан) нарт үүрэг болгосугай.

4. Захирлын 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/139 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын их сургуулийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2017 онд оюутан элсүүлэх журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Я.ТӨМӨРБААТАР

My document.2018.TUSHAAL.

20180841



Захирлын 2018 оны 04 дугаар сарын 09-ны
өдрийн А/195 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН ӨДРИЙН ХӨТӨЛБӨРТ 2018 ОНД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Монгол Улсын Их Сургууль (цаашид МУИС гэнэ)-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2018 онд оюутан элсүүлэхэд Монгол Улсын "Дээд боловсролын тухай хууль", Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 03 дугаар сарын 18-ны А/79 тоот тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам", Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/194 тоот "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тушаал, А/195 тоот "Босго оноо тогтоох тухай" тушаал, бусад холбогдох эрх зүйн акт болон энэхүү журам (цаашид журам гэнэ)-ыг баримтална.

1.2. МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг "бүртгүүлэгч", элсүүлэх оюутны тоог "хяналтын тоо", хяналтын тоонд багтан элсэх эрхээ баталгаажуулсан бүртгүүлэгчийг "элсэгч", элсэлтийн цахим бүртгэлийн системийг "элсэлтийн систем", элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг "элсэлтийн комисс" гэнэ.

1.3. МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт Улаанбаатар хот болон орон нутгаас элсүүлэх элсэгчийн хяналтын тоог Удирдах зөвлөл тогтооно.

1.4. Элсэлтийн журам, бүрэлдэхүүн сургуульд элсэх хөтөлбөр, элсэлтийн ерөнхий шалгалт (ЭЕШ)-ын оноо тооцох болон холбогдох бусад мэдээллийг <https://burtgel.num.edu.mn> цахим хуудсанд байршуулна.

1.5. МУИС-д гадаадын харьяат иргэдийг элсүүлэх асуудлыг "МУИС-д гадаадын иргэнийг элсүүлэн суралцуулах журам"-аар зохицуулна.


1.6. Бакалаврын зэрэгтэй иргэн бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэх бол энэхүү журмын 3.1, 3.2, 3.3, 3.4 дэх заалтыг хангасан байна.

ХОЁР. ЭЛСЭЛТИЙН КОМИСС

2.1. МУИС-ийн элсэлтийн комиссын дарга нь Сургалт, оюутан хариуцсан дэд захирал, нарийн бичгийн дарга нь Сургалтын нэгдсэн газрын дарга, гишүүд нь Сургалтын нэгдсэн газрын Элсэлтийн албаны дарга, Мэдээллийн технологийн газрын

дарга, Бүрэлдэхүүн сургуулийн захирал, Санхүү эдийн засгийн газрын дарга, Элсэлтийн албаны мэргэжилтэн нар байх ба МУИС-ийн захирлын тушаалаар томилно.

2.2. Комиссын дарга элсэлтийн ажлыг удирдамжаар хангаж, комиссын гишүүд элсэлтийн явцад хяналт тавих, тухайн журмаар зохицуулагдахгүй асуудлыг комиссын хурлаар хэлэлцэж, холбогдох дүрэм журамд нийцүүлэн шийдвэрлэх болон элсэлттэй холбоотой бусад үйл ажиллагааг зохицуулна.



ГУРАВ. БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИХ ШААРДЛАГА

3.1. МУИС-д элсэхийг хүссэн иргэд энэхүү журамтай танилцаж, элсэлтийн цахим бүртгэлийн системд бүртгүүлнэ.

3.2. Бүртгүүлэгч нь БСШУСЯ-ны Боловсролын үнэлгээний төв (БҮТ)-өөс зохион байгуулдаг ЭЕШ өгсөн хот, орон нутагтаа өрсөлдөнө.

3.3. Бүртгүүлэгч нь МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль, Бизнесийн сургууль, Хууль зүйн сургууль, Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль, Эрдэнэт сургууль, Завхан сургуулиас сонгож бүртгүүлнэ. Шинжлэх ухааны сургуулийн хувьд Байгалийн ухаан, Нийгмийн ухаан, Хүмүүнлэгийн ухааны салбараас сонгож бүртгүүлнэ. Бүртгүүлэгч нь өөрийн хүсэлтээр хэдэн ч сургуульд зэрэг бүртгүүлж болно.

3.4. Бүртгүүлэгч нь Боловсролын үнэлгээний төв (БҮТ)-ийн хүчинтэй батламжтай, эсвэл 2018 онд ЭЕШ өгөхөөр БҮТ-д бүртгүүлсэн байна. Бүртгүүлэгч нь МУИС-ийн оюутан бол дахин бүртгүүлэх боломжгүй.

3.5. Гадаад оронд ерөнхий боловсрол эзэмшсэн Монгол улсын иргэн нь БСШУ-ны сайдын 2013 оны 03 дугаар сарын 18-ны А/79 тоот тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”, БСШУС-ын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/195 тоот “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тушаалын 4.1.7 дахь заалтын дагуу батламж авч, БҮТ-д бүртгүүлсэн байна.

ДӨРӨВ. ЭЛСЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ

4.1. МУИС-д элсэхийг хүссэн иргэд орон даяар, цахим хэлбэрээр <https://burtgel.num.edu.mn> хаягаар бүртгүүлнэ.

4.2. Бүртгэлийг 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 09:00 цагт нээж 07 дугаар сарын 02-ны өдрийн 12:00 цагт хаана.

4.3. Шинээр бүртгүүлэгч нь элсэлтийн системд нэвтрэх эрх авахдаа шаардлагатай мэдээллээ үнэн зөв оруулан баталгаажуулна. Нэвтрэх мэдээлэл нь БҮТ-ийн системд бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээс бүрдсэн байна.

4.4. Бүртгүүлэгч нь элсэлтийн системд оруулсан мэдээллийн үнэн зөв байдлыг өөрөө хариуцах ба алдаатай, буруу мэдээлэл оруулснаас үүсэх асуудлыг МУИС хариуцахгүй.

4.5. Элсэлтийн системд нэвтрэх эрхтэй болсны дараа нэвтрэх мэдээллээ ашиглан системд нэвтэрч элсэх хүсэлт гаргах бүрэлдэхүүн/салбар сургуулиа (Журмын хүснэгт 1-ээс үзнэ үү) сонгон элсэлтийн бүртгэлийн хураамжийг цахим хэлбэрээр төлж баталгаажуулна. (цахим картаар төлбөр хийх тухай дэлгэрэнгүй зөвлөмжийг элсэлтийн бүртгэлийн системээс үзэх боломжтой).

4.6. Бүртгэлийн хураамжийг нэг удаа төлж хэдэн ч бүрэлдэхүүн/салбар сургуульд бүртгүүлэх боломжтой. Бүртгэлийн хураамжийг Удирдах зөвлөлөөс баталсан "Үйлчилгээний бусад хураамжийн хэмжээ"-д заасны дагуу авна. Бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй.

ТАВ. ЭЛСЭГЧИЙГ ШАЛГАРУУЛАХ

5.1. Элсэлтийн бүртгэл хааснаас 1 өдрийн дараа системд бүртгүүлэгчийн ЭЕШ-ын дүн, мэдээллийг БҮТ-өөс татан авч, тооцоолсон оноог бодож, жагсаалтыг бүрэлдэхүүн/салбар сургуулиар гаргана.

5.2. Бүртгүүлэгчийн тооцоолсон оноог дараах байдлаар тооцно. "Суурь" шалгалтад тооцохоор заасан хичээлээс хамгийн өндөр оноо авсан шалгалтын оноог 0.7, "Дагалдах" шалгалтад тооцохоор заасан хичээлээс хамгийн өндөр оноо авсан шалгалтын оноог 0.3 -аар үржүүлж нэмсэн нийлбэрээр "тооцоолсон оноог" бодож гаргана. Ийнхүү тооцох "Суурь" болон "Дагалдах" шалгалтын оноо тус бүр БСШУСЯ-наас баталсан босго онооноос багагүй байна. Суурь шалгалтад тооцуулсан хичээлийн оноог дагалдах шалгалтад давхар тооцуулахгүй.


5.3. Тооцоолсон оноо тэнцсэн тохиолдолд ЭЕШ-ын гүйцэтгэлийн хувийг тооцон байр эзлүүлж, элсэх эрх олгох ба гүйцэтгэлийн хувь тэнцвэл боловсролын гэрчилгээний дундаж оноог харгалзана. ЭЕШ-ын гүйцэтгэлийн хувийг тооцохдоо 5.2-т заасан аргачлалын дагуу тооцно.

5.4. Тооцоолсон оноо нь МУИС-ийн Улаанбаатар дахь бүрэлдэхүүн/салбар сургуулийн хувьд 500 оноо, Завхан, Эрдэнэт сургуулийн хувьд БСШУСЯ-наас баталсан их, дээд сургуульд элсэгчдийн хангасан байх босго онооноос багагүй байна.

5.5. Сүүлийн 2 жилийн дотор БСШУСЯ-наас тогтоосон Олон улсын олимпиадад оролцож 1-ээс 3-р байр эзэлсэн, Улсын олимпиадад оролцож Хүснэгт 2-т заасан нөхцөлийг хангасан ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчийг тухайн чиглэлээр олимпиад зохион байгуулах комиссоос олгосон батламж болон баримт бичигт үндэслэн шууд элсүүлнэ. Элсэгч нь элсэхийг хүсч буй бүрэлдэхүүн/салбар

сургуулийн суурь болон дагалдах шалгалтад тооцохоор заасан хичээлүүдээс ЭЕШ өгсөн байх ба БСШУСЯ-наас тавих ЭЕШ-ын босго оноог хангасан байна. Энэ нөхцөлийг хангасан бүртгүүлэгч “Олимпиад” гэсэн ангиллаар бүртгүүлж, журмын 4.5-д заасан бүртгэлийн хураамж төлнө.

ЗУРГАА. ЭЛСЭХ ЭРХ ОЛГОХ



6.1. Элсэх эрх олгох үйл ажиллагааг орон даяар <https://burtgel.num.edu.mn> цахим хэлбэрээр явуулна.

6.2. Бүртгүүлэгч хяналтын тоонд багтсан эсэхээ онооны жагсаалт гарсны дараа элсэлтийн системд нэвтэрч шалгана.

6.3. Журмын 5.5 дугаар заалтаар бүртгүүлэгч нь олимпиадад оролцсоныг гэрчлэх бичиг баримтын эх хувь, тэдгээрийн хуулбарын хамт бүртгэлийн хугацаанд багтаж ажлын цагаар Сургалтын нэгдсэн газрын Элсэлтийн албанд авч ирнэ. Элсэх болзол хангасан “Олимпиад” ангиллаар элсэгч элсэн суралцах гэж буй бүрэлдэхүүн/салбар сургуулийн 1 багц цагийн төлбөрийг заасан хугацаанд цахимаар төлж элсэх эрхээ баталгаажуулна.

6.4. Элсэх эрх олгох үйл ажиллагааг БҮТ-өөс ЭЕШ-ын оноог нийтэд зарласан өдрөөс эхлэн 10 хоногт багтаан зохион байгуулна.

6.5. Хэд хэдэн бүрэлдэхүүн/салбар сургуулийн хяналтын тоонд багтсан элсэгч нь зөвхөн нэг бүрэлдэхүүн/салбар сургуулийг сонгох ба энэ нөхцөлд бусад бүрэлдэхүүн/салбар сургуулийн хяналтын тооны жагсаалтаас нэр нь хасагдаж босго шугам нэгээр доошилно. Босго шугам доошилсны дүнд хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчид элсэх эрх үүсч байгааг элсэлтийн системээр шалгана.

6.6. Бүртгүүлэгч хяналтын тоонд багтаж элсэх эрхтэй болсноос хойш 24 цагийн дотор элсэх эрхээ баталгаажуулна. Энэ хугацаанд баталгаажуулаагүй тохиолдолд МУИС-д элсэхээс татгалзсан гэж үзэн жагсаалтын дараах бүртгүүлэгчид элсэх эрх шилжинэ.

6.7. Хяналтын тоонд багтаж элсэх эрхтэй болсон бүртгүүлэгч нь элсэх эрхээ баталгаажуулах эцсийн хугацааны дотор элсэлтийн системд нэвтэрч тухайн элсэн суралцах гэж буй бүрэлдэхүүн/салбар сургуулийн 1 багц цагийн төлбөрийг цахимаар төлж элсэх эрхээ баталгаажуулна. Энэ төлбөрийг суралцагчийн сургалтын төлбөрт тооцно. Элсэх эрхээ цуцлах тохиолдолд төлбөрийг буцаан олгохгүй¹.


6.8. Элсэх эрхээ баталгаажуулсны дараа элсэгч бүртгэлийн цахим маягт бөглөнө. (<https://burtgel.num.edu.mn>)

¹ Хуваарь буцааснаар дараагийн бүртгүүлэгч хуваарь авч чадахгүйд хүрч, эрх ашиг нь хөндөгддөг тул хариуцлагатай сонголт хийлгэх үүднээс урьдчилж төлүүлдэг.

ДОЛОО. ЭЛСЭГЧИЙГ БҮРТГЭХ

7.1. Элсэх эрхээ баталгаажуулсан элсэгч нь дараах бичиг баримтыг бүрдүүлэн 2018 оны 08 дугаар сарын 13-24-ний хооронд ажлын цагаар Сургалтын нэгдсэн газрын Бүртгэлийн албанд өөрийн биеэр ирж бүртгүүлнэ. Үүнд:

- Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг эх хувь (төрсний гэрчилгээ, гадаад паспорт), хуулбарын хамт (ар, өвөргүй нэг нүүрт багтаах);
- МУИС-д суралцах гэрээ (элсэлтийн системээс татан авч, ар өвөргүй хэвлэнэ);
- Бүрэн дунд боловсролын гэрчилгээ эх хувь, хуулбарын хамт (ар, өвөргүй багтаан хувилсан байх, хэрэв түүнээс дээш шатны боловсрол эзэмшсэн бол гэрчлэх баримт бичгийн эх хувь, хуулбарын хамт авчрах);
- ЭЕШ-ын батламж эх хувь, хуулбарын хамт;
- Цээж зураг 2 хувь, оюутны үнэмлэхийн шаардлагад нийцсэн цээж зураг файл хэлбэрээр (сүүлийн 3 сард авахуулсан) эдгээр бичиг баримтыг битүүмжлэл сайтай хавтсанд хийсэн байна.



НАЙМ. ЭЛСЭГЧДЭД ҮЗҮҮЛЭХ ХӨНГӨЛӨЛТ

8.1. Суурь шалгалтад тооцуулсан ЭЕШ нь 750-аас дээш оноотой Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбар, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль тус бүрийн эхний 25 элсэгчийн эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 50 хувь хөнгөлнө.²

8.2. МУИС-ийн Байгаль эх лицей сургуулийн төгсөгч нь суурь шалгалтад тооцуулсан ЭЕШ нь 650 болон түүнээс дээш оноо авч Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбар, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуульд элссэн бол эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 50 хувь хөнгөлнө.²

8.3. БСШУСЯ-наас тогтоосон Олон улсын олимпиадад оролцож 1-ээс 3-р байр эзэлсэн элсэгчийн эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 100 хувь хөнгөлнө.²

8.4. Улсын олимпиадад оролцсон элсэгчийн эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 1-р байрт шалгарсан бол 100 хувь, 2-р байрт шалгарсан бол 75 хувь, 3-р байрт шалгарсан бол 50 хувь хөнгөлнө.²

8.5. Элсэгчийн 8.1, 8.2, 8.3, 8.4 дэх хөнгөлөлт давхардсан тохиолдолд аль нэгийг нь сонгоно.

² Хичээлийн жилийн нэг улиралд суралцагчид олгох мөнгөн дүнгийн хэмжээ тухайн хөтөлбөрийн 15 багц цагийн сургалтын төлбөрөөс илүүгүй байна.

ЕС. БУСАД

9.1. Нэг бүрэлдэхүүн/салбар сургуулиас нөгөө бүрэлдэхүүн/салбар сургуульд шилжүүлэн элсүүлэхгүй ба хуваарийг бусдад шилжүүлэхийг зөвшөөрөхгүй.

9.2. Элсэх эрхээ баталгаажуулсан боловч, бүрдүүлэх бичиг баримтаа 7.1-д заасан хугацаанд авчирч бүртгүүлээгүй бол МУИС-д суралцахаас татгалзсан гэж үзэн суралцах эрхийг хүчингүйд тооцно.

9.3. Элсэлттэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдвол МУИС-д элсүүлэхгүй.

9.4. Элсэлтийн алба нь бүртгэл, элсэлттэй холбоотой мэдээллийг олон нийтэд түгээх (мэдээллийн хэрэгсэл, телевиз, вэб хуудас) болон бусад мэдээллээр ханган, зөвлөгөө өгч ажиллана.

9.5. Журмын 6.4-д заасан хугацаа дуусаагүй байхад орон нутгийн элсэх эрх олгох үйл ажиллагаа явагдаж дууссаны дараа (бүх бүртгүүлэгчээр сонголт хийсний дараа) хяналтын тоо үлдвэл Улаанбаатар дахь харгалзах бүрэлдэхүүн/салбар сургуульд шилжүүлж болно.

9.6. Элсэх эрх олгох үйл ажиллагаа явагдаж дууссаны дараа хяналтын тоо үлдвэл Элсэлтийн комиссын шийдвэрээр нөхөн элсэлт зохион байгуулж болно. Нөхөн элсэлтийг <https://burtgel.num.edu.mn> цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.

*** **

Бүрэлдэхүүн/салбар сургуульд харгалзах суурь болон дагалдах шалгалт,
сонгох боломжтой хөтөлбөрийн жагсаалт

№	БҮРЭЛДЭХҮҮН/ САЛБАР СУРГУУЛЬ	ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ		СОНГОХ БОЛОМЖТОЙ БАКАЛАВРЫН ҮНДСЭН МЭРГЭЖЛИЙН ХӨТӨЛБӨР
		“Суурь” шалгалт (70%)	“Дагалдах” шалгалт (30%)	
1	ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР	<ul style="list-style-type: none"> • Биологи • Газарзүй • Математик • Физик • Хими 	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Биологи • Газарзүй • Математик • Монгол хэл • Монголын түүх • Нийгмийн тухай мэдлэг • Физик • Хими 	<ul style="list-style-type: none"> • Багш, байгалийн ухааны боловсрол • Багш, математикийн боловсрол • Байгаль орчныг зайнаас тандан судлал • Биологи • Биологийн нөөцийн менежмент • Биохими • Биотехнологи • Газарзүй • Газар зохион байгуулалт (Төлөвлөлт, кадастр) • Геологи • Геофизик • Математик • Физик • Хими • Хот ба бүс нутгийн төлөвлөлт • Экологи
2	ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР	<ul style="list-style-type: none"> • Математик • Монголын түүх • Нийгмийн тухай мэдлэг 	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Биологи • Газарзүй • Математик • Монгол хэл • Монголын түүх • Орос хэл • Физик • Хими 	<ul style="list-style-type: none"> • Антропологи • Археологи • Нийгмийн ажил • Социологи • Сэтгүүлзүй • Сэтгэл судлал • Улс төр судлал • Эдийн засаг
3	ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ САЛБАР	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Монгол хэл • Монголын түүх • Нийгмийн тухай мэдлэг • Орос хэл 	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Биологи • Газарзүй • Математик • Монгол хэл • Монголын түүх • Нийгмийн тухай мэдлэг • Орос хэл • Физик • Хими 	<ul style="list-style-type: none"> • Багш, гадаад хэлний боловсрол • Багш, монгол хэл- уран зохиолын боловсрол • Багш, нийгмийн ухааны боловсрол • Гадаад хэлний орчуулга • Гадаад хэл, орон судлал • Түүх • Урлаг судлал • Утга зохиол судлал • Философи • Хэл, уран зохиол (Монгол хэл, уран зохиол) • Хэл шинжлэл (Монгол хэл шинжлэл, Гадаад хэл шинжлэл) • Шашин судлал

1117144746
УХД0072 9104399

4	ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААН, ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛЬ	<ul style="list-style-type: none"> • Биологи • Математик • Физик • Хими 	<ul style="list-style-type: none"> • Биологи • Газарзүй • Математик • Монгол хэл • Физик • Хими 	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчныг хамгаалах технологи • Био-инженерчлэл • Компьютерийн сүлжээ • Компьютерийн ухаан • Материал судлал • Мэдээллийн систем • Мэдээллийн технологи • Нано шинжлэх ухаан, инженерчлэл • Програм хангамж • Статистик • Сэргээгдэх эрчим хүч • Ус судлал • Химийн инженерчлэл • Сүлжээний технологи • Хүрээлэн буй орчин судлал • Хэрэглээний математик • Хэрэглээний хими • Цаг уур • Цөмийн инженерчлэл • Ойн аж ахуй • Электроник
5	БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ	<ul style="list-style-type: none"> • Математик 	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Нийгмийн тухай мэдлэг • Орос хэл 	<ul style="list-style-type: none"> • Аялал жуулчлалын менежмент • Даатгал • Зочлох үйлчилгээ • Маркетинг • Менежмент • Нягтлан бодох бүртгэл • Санхүү • Банк • Худалдаа
6	ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн тухай мэдлэг 	<ul style="list-style-type: none"> • Математик 	<ul style="list-style-type: none"> • Эрхзүй
7	ОЛОН ХАРИЛЦАА, НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Монголын түүх • Орос хэл 	<ul style="list-style-type: none"> • Математик • Монгол хэл • Нийгмийн тухай мэдлэг 	<ul style="list-style-type: none"> • Төрийн удирдлага • Олон улсын харилцаа
8	ЗАВХАН СУРГУУЛЬ	<ul style="list-style-type: none"> • Математик • Нийгмийн тухай мэдлэг • Физик • Монгол хэл • Англи хэл 	<ul style="list-style-type: none"> • Математик • Нийгмийн тухай мэдлэг • Англи хэл • Математик • Физик • Хими • Монгол хэл 	<ul style="list-style-type: none"> • Маркетинг • Менежмент • Нягтлан бодох бүртгэл • Санхүү • Банк • Худалдаа • Электроник • Аялал жуулчлалын менежмент • Багш, гадаад хэлний боловсрол (Англи хэл)
9	ЭРДЭНЭТ СУРГУУЛЬ	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Орос хэл • Монгол хэл • Математик 	<ul style="list-style-type: none"> • Монгол хэл • Нийгмийн тухай мэдлэг • Англи хэл • Орос хэл 	<ul style="list-style-type: none"> • Багш, гадаад хэлний боловсрол • Гадаад хэлний орчуулга • Багш, монгол хэл-уран зохиолын боловсрол • Даатгал • Маркетинг • Менежмент • Нягтлан бодох бүртгэл • Санхүү • Банк

- МУИС-д элсэхийг хүссэн иргэн хүснэгтэд заасан бүрэлдэхүүн/салбар сургуульд бүртгүүлэх бөгөөд тооцоолсон оноогоороо элсэлтийн хяналтын тоонд багтан элсэх эрхээ баталгаажуулсан тохиолдолд МУИС-д элсэх эрхтэй болно. Элсэгч нь нэг жил суралцсаны дараа тухайн бүрэлдэхүүн/салбар сургуулийн бакалаврын бүх хөтөлбөрөөс мэргэжлийн хөтөлбөр сонгон суралцах бөгөөд цуглуулсан багц цаг, сурлагын дүн, анх элсэхээр бүртгүүлэхдээ тооцоолсон оноо өндөр байх тусам мэргэжил сонгохдоо давуу эрх эдэлнэ. Түүнчлэн зарим хөтөлбөрийн хувьд бэлтгэж буй мэргэжил, шинжлэх ухааны онцлогоос үүдэн оюутанд тусгай шаардлага тавина.

- МУИС-д элссэн оюутан нь өөрийн сонгосон үндсэн мэргэжлээс гадна "Хавсарга мэргэжил", "Хос мэргэжил"-ээр сонгон суралцах боломжтой. Жишээлбэл, Шинжлэх ухааны сургуульд Физик мэргэжлээр суралцаж байгаа оюутан Бизнесийн сургуулийн Менежмент хөтөлбөрөөр хавсарга мэргэжил эзэмших боломжтой.

- Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбарын Математик, Физик, Хими, Биологи хөтөлбөрийг сонгосон оюутнуудын нийт суралцах хугацааны төлбөрийг голч дүнгээс хамааран 50 хүртэлх хувиар хөнгөлнө.

Олимпиадын нөхцөлөөр элсүүлэх



№	Бүрэлдэхүүн сургууль/салбар	Олимпиадын чиглэл	Элсүүлэх нөхцөл
1	Шинжлэх ухааны сургууль- Байгалийн ухааны салбар	<ul style="list-style-type: none"> • Биологи • Газарзүй • Математик • Физик • Хими 	Оролцогч 1117144746 УХД0072 9104399
2	Шинжлэх ухааны сургууль-Нийгмийн ухааны салбар	<ul style="list-style-type: none"> • Математик • Нийгмийн Ухаан • Түүх 	1-ээс 3-р байр
3	Шинжлэх ухааны сургууль- Хүмүүнлэгийн ухааны салбар ³	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Монгол хэл • Орос хэл • Түүх • Хятад хэл 	1-ээс 3-р байр
4	Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль	<ul style="list-style-type: none"> • Биологи • Газарзүй • Математик • Физик • Хими • Мэдээлэл зүй • Техник технологи 	Оролцогч
5	Бизнесийн сургууль	<ul style="list-style-type: none"> • Математик 	1-ээс 3-р байр
6	Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Орос хэл • Түүх • Математик • Нийгмийн ухаан 	1-ээс 3-р байр
7	Хууль зүйн сургууль	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн ухаан 	1-ээс 3-р байр
8	Завхан сургууль	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Математик • Нийгмийн ухаан • Орос хэл • Физик 	Оролцогч
9	Эрдэнэт сургууль	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Орос хэл • Монгол хэл • Математик 	Оролцогч

*** **

³ Монголын сайхан бичигтэн улсын уралдааны 1-ээс 3-р байрт шалгарсан ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчийг Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарт шууд элсүүлэн суралцуулна.